



**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ**

2017 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

Зарим аж ахуйн нэгж байгууллагуудын
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох,
түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3, 14 дүгээр зүйлийн 14.1.5, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны “Хяналт-шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” А/137 дугаар тушаалын биелэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгасан нэгдүгээр хавсралтад заасан 6 байгууллагын Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн сэргээж, үйл ажиллагаа явуулахыг нь зөвшөөрсүгэй.


2. Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй хоёрдугаар хавсралтад заасан 12 байгууллагын Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

3. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүлээж аваагүй, гаргасан зөрчлөө арилгаагүй гуравдугаар хавсралтад заасан 9 байгууллагын Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

4. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт болон харьяалах татварын албанд нь хуулийн хугацаанд багтаан мэдэгдэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т даалгасугай.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д үүрэг болгосугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн
А/202 тушаалын хэвсрэлт 01

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ЗУУЧЛАХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЬ СЭРГЭЭЖ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛАХЫГ НЬ ЗӨВШӨӨРСӨН
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР

№	Байгууллагын нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар
1	"Биллихиро" ХХК	5409942	2016/47
2	"Бюула" ХХК	5824141	2016/42
3	"Жэй Пи Партнерс" ХХК	6070094	2016/64
4	"Тоба маркет" ХХК	5682762	2016/50
5	"Трансформер" ХХК	6022146	2016/56
6	"Си Эс Эм Эм" ХХК	5169445	2016/71


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 11 дүгээр сарын 21 ныгөдрийн
4/202 тушаалын хавсралт 02



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ЗУУЧЛАХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЬ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР

№	Байгууллагын нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар
1	"Аск Эба" ХХК	5284589	2016/59
2	"Баян Алтан бүхт" ХХК	5586208	2016/39
3	"Би Жи Сервис" ХХК		2016/67
4	"Кайкакү" ХХК	6071511	2016/69
5	"Монжа Интернешнл Эдүкейшн" ХХК	6061826	2016/55
6	"Монфужи" ХХК	5478995	2016/58
7	"Монгол стандарт" ХХК		2016/70
8	"Сарухай" ХХК	6017371	2016/41
9	"Ти Ай Партнерс" ХХК		2016/65
10	"Хар-Од" ХХК	5462339	2016/46
11	"Эрмэг жигүүр" ХХК		2016/72
12	"Эрхэс Очир Эрдэнэ" ХХК	5969425	2016/61

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн
А/202 тушаалын хэвсрэлт 03



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ЗУУЧЛАХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН
БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР

№	Байгууллагын нэр	Регистрийн дугаар	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар
1	"Заг" ХХК	2061821	2015/05
2	"Голден хаив" ХХК		2016/60
3	"Нарт Атас" ХХК	5045568	2016/63
4	"Оюу цацрахуй" ТББ	8182638	2015/32
5	"Соёл-Эрдэм" дээд сургууль	2073366	2015/07
6	"Хонгор түрүү" ХХК	5256295	2015/26
7	"Хэрэм зам" ХХК	2670054	2016/66
8	"Эдосолюншнс монголиа" ХХК	5199476	2015/14
9	"Экспертлинк" ХХК	5307813	2016/53